МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ДОТООД АУДИТЫН 2020 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2021.03.16

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТАЙЛАН

1. Тайлангийн зорилго

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлсан “Дотоод аудитын дүрэм”-ийн

- ✓ 4.2. “Дотоод аудитын нэгж нь төсвийн ерөнхийлөн захирагчид ажлаа хариуцан тайлагнана”
- ✓ 7.6. “Дотоод аудитын нэгжийн дарга нь дотоод аудит, хяналт шалгалтын дүн, дотоод аудитын жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, хөндлөнгийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Дотоод аудитын хороо, төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж тайлагнана.” гэж заасны дагуу Дотоод аудитын 2020 оны ажлыг тайлагнахад тайлангийн зорилго оршино.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТАЙЛАН

2020 онд санхүү, дотоод аудитын **19** ажил хийж гүйцэтгэсэн.

ТӨЛӨВЛӨГӨӨТ 9 АЖИЛ

ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС 10 АЖИЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТАЙЛАН

2. Төлөвлөгөөт ажил

1. “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд аудит /2019 оны жилийн эцсээр/
2. “Налайхын дулааны станц” ТӨХК-д санхүүгийн дотоод аудит
3. “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засварын ажилд санхүүгийн дотоод аудит
4. “Даланзадгадын ДЦС” ТӨХК-д санхүүгийн дотоод аудит
5. “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд дотоод аудит /2020.10 сар, 2020 оны эхний хагас жил/
6. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д хяналт шалгалт
7. ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтэд тавих хяналт
8. ЗГ-ын 29 дүгээр тогтоолоор батлсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.2 дах заалтын дагуу Сангийн яаманд шилэн дансны улирлын тайлан илгээлт
9. Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.9-д заасны дагуу Сангийн яаманд дотоод аудитын нэгжийн хагас жил болон жилийн эцсийн тайлан илгээлт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТАЙЛАН

3. Төлөвлөгөөт бус ажил

1. “СЭХҮТ” ТӨҮГ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт
2. “ДСЦТС” ХХК-ийн үнэ тариф тогтоосон байдалд үнэлэлт, дүгнэлт
3. ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын контрактыг дүгнэх ажлын хэсэг
4. ТӨҮГ-ын захирлын контрактыг дүгнэх ажлын хэсэг
5. “ЭБЦТС” ТӨХК-д хяналт шалгалт
6. “Баганаур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт
7. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-д хяналт шалгалт
8. 2019 оны үнэ тарифын зохицуулалтын үр дүн, “Нэг худалдан авагчтай загвар”-ын санхүүгийн үзүүлэлтийн талаар мэдээлэл, танилцуулга
9. Хязгаарлалттай дүгнэлт авсан ЭХЯ, “ДҮТ” ХХК, “Эгийн голын усан цахилгаан станц” ТӨХХК-ийн танилцуулга.
10. “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт /2020.10.31-ний байдлаар/

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТАЙЛАН

Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт

Салбарын хэмжээнд нийтлэг илэрч буй үл нийцлүүд:

- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган ажиллахгүй байгаагаас өртөг, зардал нэмэгдэх, үр ашиггүй зардал гарах.
- ТУЗ-ийн тогтоол шийдвэргүй үндсэн цалинг нэмэгдүүлэх, жилийн үр дүнгийн шагнал олгох, үндэслэлгүйгээр илүү цагийн хөлс бодож олгох.
- Төлөвлөгөөний тодотгол хийхдээ орлогын өсөлттэй уялдуулж зардлыг төлөвлөхгүй, эх үүсвэргүй зардлуудыг тусгах.
- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль”-ийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхгүй байх.
- Хууль, журам зөрчсөн орон тоо, бүтэц зохион байгуулалттай холбоотой томилгоо, ажлаас чөлөөлсөн асуудлууд
- Гэрээний үүрэг зөрчиж, биелэлтэд хяналт тавиагүй
- Өр, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулалт хангалтгүй, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТАЙЛАН

Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт

Аудитад хамрагдсан байгууллагуудад хүргүүлсэн нийтлэг зөвлөмж:

- Хууль тогтоомж, холбогдох дүрэм журмыг мөрдөн ажиллах.
- Мөнгөн урсгалын зөв оновчтой бодлого хэрэгжүүлж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах, өр, авлагыг нэмэгдүүлэхгүй байх, компанийн ашигт ажиллагааг хангах.
- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хэрэгжүүлж ажиллах, төлөвлөгөөт зардлыг хэтрүүлэхгүй, гүйцэтгэлд хяналт тавих.
- Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын ажлуудыг тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөх, ажлыг зураг төсвийн дагуу графикт хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх, хэрэгжилтэд хяналт тавих.
- Үйлдвэрлэлийн бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн сэлбэг, бараа материалыг оновчтой төлөвлөж, агуулахын үлдэгдлийг нэмэгдүүлэхгүй байх.
- Санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах
- Удирдах дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах, хариуцсан ажилдаа хайнга хандаж, зүй бус үйлдэл гаргаж ажилласан ажилтнуудад арга хэмжээ авч, хариуцлагын тогтолцоог сайжруулах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудитын талаар

Төрийн аудитын байгууллагаас Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нийт 32 байгууллагад санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэж, 29 байгууллагад ЗӨРЧИЛГҮЙ санал дүгнэлт, 3 байгууллагад ХЯЗГААРЛАЛТТАЙ санал дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн үр дүнгийн нэгтгэлийг доорх хүснэгтэд харуулав. Үүнд:

№	Утга	Тоо	Дүн /сая.төг/	Биелэлт /2020.11.01/
1	Төлбөрийн акт	5	445.3	100%
2	Албан шаардлага	23	4,204.1	83.9%
3	Зөвлөмж	115	8,883.3	82.5%
	Нийт дүн		13,532.7	88.8%

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хангахаар авч хэрэгжүүлсэн ажил

- Сайдын 2020.05.19-ний өдрийн а/1695 албан тоотоор ҮАГ-аас өгсөн аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг хангаж ажиллах үүрэг даалгаврыг салбарын үйлдвэр компаниудад хүргүүлсэн.
- Санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлттэй “ДҮТ” ХХК, “ЭГУЦС” ТӨХХК-д албан даалгаврыг Сайдын 2020.05.19-ний өдрийн а/1686 албан тоотоор хүргүүлсэн.
- Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж 2020.05.25-ны өдөр Сайдаар батлуулан, мөрдөж, биелэлтэд хяналт тавин ажилласан.
- Санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд 2020 оны хагас жилийн байдлаар зөвлөмжийн биелэлтэд хяналт хийхэд 76,9 хувиар үнэлэгдсэн. Биелэлтийг хангах үүрэг даалгаврыг хүргүүлж ажилласан.
- Төрийн аудитын тухай хуулийн шинэчлэлтийг 2020.06.01-нээс мөрдөж болсонтой холбоотойгоор ҮАГ-аас хийсэн санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар Сайдын 2020.08.27-ны өдрийн а/2666 албан даалгаврыг 32 байгууллагад хүргүүлсэн.
- Үндэсний аудитын газраас хийсэн явцын аудитаар зөвлөмжийн биелэлтийг тайлагнаж хамтарч ажиллав. Явцын аудитаар зөвлөмжийн биелэлт 88.8 хувьтай үнэлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТАЙЛАН

Төрийн аудитын акт, албан шаардлагын биелэлтийг хангах үндэслэл

Төрийн аудитын тухай хууль шинэчлэн батлагдаж, 2020.06.01-нээс эхлэн мөрдөж байна. Хуульд орсон дараах өөрчлөлтүүд нь салбарын харьяа байгуулагуудын санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд зайлшгүй хяналт тавих эрх зүйн үндэслэл болж байна. Үүнд:

- 42.1. Шалгагдагч этгээд нь хүчин төгөлдөр болсон *<u>албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй,</u>* аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.
- 42.3. Энэ хуулийн 42.1-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага *<u>тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.</u>*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТАЙЛАН

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Салбарын хэмжээнд 2018 оны эцэст 84,3%, 2019 оны эцэст 93,8%-тай үнэлэгдсэн бол 2020 оны жилийн эцсээр 98.7%-иар үнэлэгдэж, үзүүлэлт өссөн нь харьяа байгууллагууд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хариуцлага сайжирч байгааг харуулж байна. Сүүлийн 3 жилээр харьцуулбал дараах үр дүнтэй байна. Үүнд:





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ТАЙЛАН

Дотоод аудитын 2020 оны төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ буюу төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь
1	“Налайхын дулааны станц” ТӨХК, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК Сайдын багцын 2020 оны төсвийн урсгал зарлага Сайдын багцын 2020 оны худалдан авалт	биелсэн	100%
2	Шилэн данс-2019 оны жилийн эцсийн байдлаар Шилэн данс-2020 оны эхний хагас жилийн байдлаар	биелсэн	100%
Төлөвлөгөөт бус ажил:			
3	“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт /2020.10.31/	биелсэн	100%